

ДАХИН ГЭРЛЭСЭН ГЭР БҮЛТЭЙ АЖИЛЛАХ НИЙГМИЙН АЖЛЫН
АРГА ЗҮЙН ЗАГВАР БОЛОВСРУУЛЖ, ТУРШСАН НЬ

Ч. Должинсүрэн
Доктор (Ph. D.)

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

doljinsuren012@gmail.com

Ж. Буянхишиг
Докторант

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

j.buyankhishig@must.edu.mn

Б. Болормаа
Доктор (Ph. D.)

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

bumbaalai8888mn@yahoo.com

Хураангуй: Манай орны хувьд дахин гэрлэлтийн асуудал нийгмийн шинжлэх ухаанд төдийлөн тусгагдаж гарч ирээгүй байгаа боловч бодит амьдрал дээр тус асуудал нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн анхаарах шаардлагатай асуудлуудын нэг болсон байна. Иймээс дахин гэрлэсэн гэр бүлийг тогтвортой байлгах, хойд аав, ээжийн харилцааг эерэг болгох зэрэг олон асуудлууд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, гэр бүл судлаач нар хамтран ажиллаж гадаадын амжилттай загварыг хэрэгжүүлэн ажиллах нь дахин гэрлэсэн гэр бүлийн хүрээнд чухал асуудал болоод байна.

Түлхүүр үгс: Дахин гэрлэсэн гэр, нийгэм сэтгэл зүйн загвар, хамтарсан баг

Гэр бүлийн салалтаас үүдэлтэй сэтгэлийн зовлонг мартагнуулж, түүнээс ангижруулах нэгэн гарц бол дахин гэрлэх явдал юм. Гэр бүлээ цуцлуулсан хүмүүс олон янзын арга, хэлбэрээр бие биенээ эргүүлж, улмаар гэрлэлтээ албан ёсоор батлуулж байгааг дахин гэр бүл бологсдыг бүртгэсэн статистик баримт сэлтээс үзэж болохоор байна. M.D. Bramlett, W.D. Mosher нарын явуулсан судалгаанд салсан хүмүүсийн дөрөвний гурав орчим нь дахин гэрлэж байгаа бол R.M. Kreider-ийн судалгаагаар гэр

бүлээ цуцлуулах, дахин амьдрал зохиохын хоорондох хугацаа ойролцоогоор 3-аас 4 жил байгаа аж (Bramlett M.D., Mosher W.D., 2001; Kreider R.M., 2005). Дахин гэрлэсэн гэр бүл гэдэг нь өмнө нь гэр бүл зохиож байсан хосууд хоорондоо гэрлэх явдал юм. Гадаадын улс орнуудад уг үзэгдлийг тайлбарлахдаа “холимог гэр бүл”, “2 дахь гэр бүл” /англи хэлэнд “step family”/ гэх мэтчилэн томъёолсон байдаг.²⁴

АНУ-ын судлаачдын тогтоосноор²⁵ одоогийн байдлаар АНУ-д гэр бүл болоод салсан эрчүүдийн 50 хувь нь, эмэгтэйчүүдийн 33 хувь нь гэр бүлээ цуцлуулаад 1 жил өнгөрсний дараагаар дахин гэр бүлтэй болдог байна, харин 3 жилийн дараагаар бол эрчүүдийн 83 хувь нь, эмэгтэйчүүдийн 75 хувь нь дахин гэрлэдэг гэсэн тоо гарчээ. Хүүхэдтэй салсан эмэгтэйчүүдийн 50-с дээш хувь нь салсаны дараах 5 жилд багтан дахин гэрлэдэг бол э хувь нь 10 жилд багтан дахин гэрлэдэг.

ОХУ-н хувьд дахин гэрлэлтийн асуудлын хувьд нөхцөл байдал арай өөр харагдаж байна. 25 наснаас өмнө салсан эмэгтэйчүүдийн 2/3 хувь нь салсаны дараахь 10 жилийн дотор дахин гэрлэсэн байдаг бөгөөд насны түвшин нэмэгдэх тусам дахин гэрлэх магадлал буурсан үзүүлэлттэй гарчээ.²⁶ Ерөнхийдөө салсаны дараахь 20 жилийн турш эмэгтэйчүүдийн талаас бага хувь нь дахин гэр бүлтэй болдог байна.

Манай орны хувьд дахин гэрлэлтийн асуудал нийгмийн шинжлэх ухаанд төдийлөн тусгагдаж гарч ирээгүй байгаа боловч бодит амьдрал дээр тус асуудал нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн анхаарах шаардлагатай асуудлуудын нэг болсон байна. Судлаач Б.Оюун-Эрдэнийн үзэж байгаагаар “Монгол улсад явагдсан нийгмийн шилжилтийн үе болон дэлхий дахины даяарчлал, соёлын глобалчлал нь монгол гэр бүлийн бүтэц, хэв маягт ихээхэн өөрчлөлтийг авчирч байна²⁷”. Тус судалгаагаар монгол гэр бүлийн өмнө тулгамдаж буй нэгэн асуудал нь улс дамнасан гэр бүл буюу гэр бүлийн аль нэг гишүүн гадаадад суралцах эсвэл ажиллах зорилготойгоор гэр бүлээсээ хол амьдрах асуудал гэж тодорхойлогджээ. Гадаадад ажиллагчдын дийлэнх хувь нь хөдөлмөрийн насны эрчүүд эзэлж байгаагаас 53,5 хувь гэр бүлтэй боловч дийлэнх хувь нь гэр бүлтэйгээ хамт байж чадахгүй байгаа нь гэр бүлийн бат бөх байдал, салалтанд, мөн цаашлаад давтан гэр бүл болох байдал шууд нөлөө үзүүлж байна гэж хэлж

²⁴ Cartwright C., Gibson K. *The effects of co-parenting relationships with ex-spouses on couples in step-families* // Australian Institute of Family Studies. 2012

²⁵ Hetherington E.M. *Coping with Divorce, Single-Parenting, and Remarriage: A Risk and Resiliency Perspective*. Mahwah, NJ: Lawrence Erlbaum. 1999

²⁶ Белова В.А. Повторные браки и рождаемость: в кн.: Социально-демографические исследования брака, семьи, рождаемости и репродуктивных установок. Ереван, 1993. С. 13-15

²⁷ Б. Оюун-Эрдэнэ “Монгол гэр бүлийн бүтэц, хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал” // Шинжлэх ухааны академийн мэдээ. 2012 он №03, хх. 37-49


болно. Сүүлийн жилүүдэд гэр бүлийн тогтвортой байдал алдагдсанаар гэр бүлийн уур амьсгал, дотор нь өсч торниж буй хүүхдүүдийн нийгэм-сэтгэл зүйн асуудлууд газар авсаар байна. Монгол орны хувьд 2017 оны байдлаар гэр бүлгүйгээр хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тоо гэр бүлтэйгээр хүүхэд төрүүлсэн эхийн тоон үзүүлэлтийн 15 хувийг эзэлж байна.

Дахин гэрлэсэн гэр бүлийн хөгжлийн онцлог нь анхны гэр бүлийг бодвол илүү нарийн, төвөгтэй байдаг. Тэрээр энгийн гэр бүлийн хөгжлийн үе шат дээр нэмээд салалтын шат, бүрэн бус гэр бүлийн шат, дахин гэрлэх шат зэргийг багтаадаг.

ОХУ-ын Гэр бүлийн нийгэмлэгээс нийгмийн ажилтан, сэтгэл судлаач, гэр бүл судлаач нарт санал болгон гаргасан “*Дахин гэрлэсэн гэр бүлд үзүүлэх нийгэм сэтгэл зүйн загвар*”-ыг бид энэхүү илтгэлээрээ олны хүртээл болгож байна.

Энэхүү илтгэлийн хүрээнд тус загварыг Монгол хүний онцлог, улс орны байдал, нийгмийн ажлын үйлчилгээний онцлогт тохируулан нутагшуулан дахин гэр бүл болж байгаа 10 гэр бүлд энэхүү загварын хүрээнд үйлчилгээ үзүүллээ.

Дахин гэрлэсэн гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаанд түгээмэл гардаг асуудлыг шийдвэрлэх, тогтвортой байдлыг бий болгох, хүүхдийн бие сэтгэлзүйн хөгжлийг эерэгээр хангах, дахин гэрлэлтээс үүдэх сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэхэд “*Дахин гэрлэсэн гэр бүлд үзүүлэх нийгэм сэтгэл зүйн загвар*”-ын зорилго оршино. Энэхүү загвар нь дараах 5 үе шатаас бүрдэнэ.



Загварын туршилтийн үйлчилгээнд хамрагдсан гэр бүлийн өгөгдөлд дүн шинжилгээ хийв.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

	Утга	Үзүүлэлт	Хувь
1	Насны бүлэг	30-45	74.2
		45-50	34
2	Хүйс	Эрэгтэй	63
		Эмэгтэй	37
3	Ажил эрхлэлт	Улсын	81.1
		Хувийн	18.9
4	Хүүхдийн тоо	Дунд анги	27
		Ахлах анги	12
		Бага анги	29
		5-с доош нас	32
5	Эцгийн боловсрол	Бүрэн бус дунд	15.4
		Бүрэн дунд	32.5
		Дээд	52
6	Эхийн боловсрол	Бүрэн бус дунд	26.2
		Бүрэн дунд	28.1
		Дээд	45.5

Дээрх үзүүлэлтээс хархад үйлчилгээнд хамрагдсан дахин гэрлэж байгаа гэр бүлийн эхнэр нөхрийн 50 гаран хувь нь дээд мэргэжилтэй байгаа нь энэхүү загвар амжилттай болох магадлалыг харуулж байна.

Үйлчилгээнд хамрагдсан гэр бүлийн гишүүдийн дунд энэхүү загвар таны гэр бүлийн харилцаанд эерэг өөрчлөлт оруулсан уу? гэсэн асуултад 8 гэр бүлийн гишүүд эерэг хандлага ажиглагдаж эхэлж байгаа, 1 гэр бүлийн гишүүд одоогоор хариулж мэдэхгүй байна, 1 гэр бүл бидэнд хугацаа хэрэгтэй гэж хариулсан байна.

Иймээс энэхүү загварыг хороо дүүргийн нийгмийн ажилтан, мэргэжлийн сэтгэл зүйч нар хамтран хэрэгжүүлэн нэн шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

“Дахин гэрлэсэн гэр бүлд үзүүлэх нийгэм сэтгэл зүйн загвар”-
нэн шаардлагатай эсэх



- эерэг хандлага бий болж эхлэсэн тул шаардлагатай
- цаг хугацаа хэрэгтэй
- мэдэхгүй

I. СОНГОХ ҮЕ

Дахин гэрлэсэн гэр бүлийг сонгон авах үзүүлэлтүүд

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Өрхийн шууд хамаарах шинж	Үзүүлэлтүүд	Нотолгоо
Нийгэм, хүн ам зүй	Өрхийн бүтэц/хэмжээ	1. Дахин гэрэлсэн байх; 2. Ам бүлийн тоо 3 буюу түүнээс дээш байна. Ам бүлийн тоо гэдэгт сүүлийн 1 жилд хамт нэг гэрт амьдарсан хүмүүсийг оруулна. 3. 0-16 насны хоёр ба түүнээс дээш хүүхэдтэй өрх;
	Шилжилт хөдөлгөөн	1. Амьдарч буй орон нутагтаа бүртгэлтэй байх; 2. Сүүлийн нэг жилд тухайн орон нутагтаа тогтвортой амьдарсан байх;
Эдийн засгийн байдал	Орлого	1. Өрхийн нэг хүнд ногдох сарын дундаж орлого 800,000 төгрөг буюу түүнээс доош; 2. Улирлын чанартай ажил эрхэлдэг хүн байгаа эсэх; 3. Хөдөлмөрийн насны ажил эрхэлдэггүй хүн байгаа эсэх;
Нийгэм байдал	Эрүүл мэнд	1. Харьцангуй эрүүл байх; 2. Нийгэм сэтгэл зүйн зөвлөгөөнд өөрийн хүсэлтээр төлөвлөгөөний дагуу хамрагдах боломжтой байх;
	Боловсрол	1. Сургуулийн насны хүүхэдтэй тохиолдолд сургууль завсардуулаагүй байх; 2. Сургууль завсардсан бол тухайн оршин сууж байгаа харъяаны сургуульдаа хүсэлт гаргасан байх; 3. Төсөлд хамрагдах гишүүн нь бүрэн бус дунд түүнээс дээш боловсролтой байх;

II. АСУУДАЛ ТОДОРХОЙЛОХ ҮЕ

Гэр бүлийн харилцааны индекс (ifr)-ээр дахин гэрлэсэн гэр бүлийн асуудлыг тодорхойлох

Товч агуулга.

Гэр бүлийн харилцааны асуудлыг үнэлэх зориулалттай гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцааны асуудлын цар хүрээ, хүнд ноцтой байдлыг хэмжих зориулалт бүхий 25 даалгавраас бүрдсэн үнэлгээний арга юм. IFR-ийг гэр бүлийн нэг эсвэл хоёр болон түүнээс олон гишүүдийг үнэлэхэд хэрэглэж болох бөгөөд хүн тус бүр гэр бүлийн ерөнхий уур амьсгалыг үнэлнэ. IFR нь огтлолцсон хоёр оноотой. Эхний оноо нь 30 (+ - 5). Энэхүү онооноос доогуур оноо нь харилцааны асуудал бэрхшээл байхгүй болохыг илтгэнэ. Харин 30-аас дээш оноо нь клиникийн ач холбогдол бүхий асуудал бэрхшээл оршиж байгааг илтгэнэ. Мөн шаардлагатай бол гишүүдтэй ярилцах аргыг хэрэглэж болно.

Заавар.

Гэр бүлийн гишүүд бүрээс бэлтгэгдсэн асуулгаар нийгмийн ажилтан асуулга авч, сэтгэл зүйчийн тусламжтайгаар хамтран гэр бүлийн

зөрчилдөөнийг тогтоож даараагын үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргана.

/Асуулт боловсруулалтыг хавсаргав/

III. ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ҮЕ

Товч агуулга

Тус зөвлөгөөг дахин гэр бүл бүрэлдэн бий болох үе шат тус бүртэй уялдуулан өгөх шаардлагатай бөгөөд нийгмийн ажилтан – сэтгэл зүйч – эрх зүйч нарын хамтарсан баг ажиллана.

Заавар:

Нийгмийн ажилтан – сэтгэл зүйч – эрх зүйч нарын хамтарсан баг мэргэжлийн түвшинд доорх заагдсан чиглэлүүдээр гэр бүлүүдэд зөвлөгөө өгнө.

Дахин гэрлэсэн гэр бүлийн үе шатуудын дагуу өгөгдөх зөвлөгөө

№	Гэр бүл бүрэлдэх үе шат, түүний зорилго	Сэтгэл зүйн зөвлөгөө	Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө	Хуулийн зөвлөгөө	Гарах үр дүн
1	<p>Салалт:</p> <ol style="list-style-type: none"> Сэтгэл зүйн бие даасан байдлаа олж авах Салалттай холбоотой сөрөг мэдрэмжүүдээ илэрхийлэх Макро түвшинд салалтын тухай мэдээнд үзүүлж буй хариу үйлдэлд дасах 	<ul style="list-style-type: none"> Өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх Сөрөг сэтгэл хөдлөлөө хүлээн авч илэрхийлэхэд суралцах Салсан эхнэр /нөхөр/- тэйгээ энгийн эерэг харилцаа үүсгэх Дахин хүнд итгэх итгэлийг бий болгох Хүүхдийг эхнэр, нөхрийн зөрчилд буруугүй гэдгийг ойлгуулж сэтгэл зүйн хувьд дэмжлэг үзүүлэх 	<ul style="list-style-type: none"> Эцэг эхийн үүргүүдийг хуваарилах Гэр бүлийн найз нөхөд, хамаатан саданд салалтын тухай мэдээлж цаашдын харилцаанд сөрөг хандлага гаргахгүй байх тал дээр анхааруулах 	<ul style="list-style-type: none"> Хууль ёсны дагуу гэр бүлийг цуцлуулах Хүүхдийн асран хамгаалалгчийг томилох Хүүхдэд тэтгэмж тогтоолгох Эд хөрөнгийн хуваарилалт хийх 	<ul style="list-style-type: none"> Салсан хосууд гэр бүл цуцлалтыг бүрэн хүлээн авч ухамсарлах Салсан хосууд цаашид энгийн эерэг харилцааг үргэлжүүлэх боломжтой байх Салсан эцэг /эх/ цаашид хүүхэдтэйгээ уулзах боомж боллоцоогоор хангагдах
2	<p>Өрх толгойлсон эцэг /эх/ бүхий гэр бүл:</p> <ol style="list-style-type: none"> Гэр бүлийн хэрэгцээг бүрэн хангахуйц орлоготой болох Бие даан амьдрах боломжгүй өрх толгойлсон эцэг /эх/-үүд өөрийн эцэг эхтэйгээ хамт амьдрах тохиолдолд хүүхдүүдээ өөрийн эцэг, 	<ul style="list-style-type: none"> Өрх толгойлсон эцэг /эх/ өөрийн гэр бүлд эцэг, эхийн үүргүүдийг зэрэг гүйцэтгэж байгаагаа ухамсарлах Өөрийн нөхцөл байдалд гутрахгүй өөдрөг амьдрах арга барилд суралцах 	<ul style="list-style-type: none"> Гэр бүлийн ойрын хүрээллийн субъектуудтай /өвөө, эмээ/ харилцах харилцааны чиг шугамыг тогтоох Өрх толгойлсон эцэг /эх/ хүүхдүүдээс тусламж хүсч байгаа тохиолдолд нас, боломжинд нь тохирохуйц 	<ul style="list-style-type: none"> Өрх толгойлсон эцэг /эх/ хүүхдийг салсан эх /эцэгтэй/ нь уулзахад саад учруулахгүй байх Өрх толгойлсон эцэг /эх/ ямар нэгэн байдлаар хүүхдийн эрхийг зөрчих асуудал 	<ul style="list-style-type: none"> Тус гэр бүл өөрийн эдийн засгийн болон сэтгэл зүйн хэрэгцээгээ хангах чадвартай болох Гэр бүлд хүүхэд болон эцэг /эх/-ийн нас, биенд тохирохуйц үүрэг хэрэгждэг байх

	эхийн байр сууриа хадгалж үлдэх		байгаа эсэхийг нягтлах	гаргахгүй байх	
3	<p>Өрх толгойлсон эцэх /эх/ дахин дотно харилцаа үүсгэх:</p> <ul style="list-style-type: none"> Салсан хүний хувьд дахин хүнд итгэж сурах Өмнөх сөрөг туршлагаас суралцан “сайн” харилцаа үүсгэх чадвартай болох 	<ul style="list-style-type: none"> Шинэ харилцаанаас “айх” айдсыг даван туулах Хүүхэдтэй харилцах харилцаанд шинэ харилцааны нөлөөллийг бага болгох Гэр бүлийн гишүүд шинэ гишүүнтэй харилцаж цаашдын хэтийн төлөвийг тодорхойлох 	<ul style="list-style-type: none"> Хүүхэд шинэ харилцааг ойлгож хүлээн зөвшөөрөхөд дэмжлэг тусалцаа үзүүлэх Гэр бүлийн ойрын хүрээлэлд шинэ харилцааны тухай мэдээллэх 	<ul style="list-style-type: none"> Тус үе шат дээр гэр бүлийн тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу гэр бүлүүдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгөгдөнө. 	<ul style="list-style-type: none"> Хуучин нөхөр /эхнэр/-ээс сэтгэл зүйн хувьд тусгаар болох Шинэ харилцаагаа амжилттай авч явах арга барилтай болох Гэр бүлийн гишүүд нэг нэгэндээ тэвчээртэй, итгэлтэй хандах нөхцөл бүрдүүлэх
4	<p>Дахин гэрлэсэн гэр бүл:</p> <ul style="list-style-type: none"> Дахин гэрлэсэн гэр бүл бол 3 ба түүнээс илүү гэр бүлүүдийн нийлбэр юм гэдгийг ухамсарлах Хүүхдүүдийн зүгээс гэр бүлд хандах эерэг хандлагыг төлөвшүүлэх Төрсөн биш эцэг /эх/-ийн хувьд эхлээд хүүхэдтэй найзын харилцаа үүсгэж дотносохын хирээр хүмүүжүүлэх арга хэмжээ авах 	<ul style="list-style-type: none"> Шинэ гэр бүлийн дүрэм, журамыг тодорхойлох Гэр бүлийн гишүүд хоорондын харилцааны заагийг нарийн тогтоох Хойд эцэг /эх/-ийн байр суурийг хүүхдүүдийн хувьд бага багаар нэмэгдүүлэх арга хэмжээ авах Эцэг /эх/-ийн хувьд хүүхдүүдийн өмнө гэмших мэдрэмжээ даван туулах 	<ul style="list-style-type: none"> Хүүхдүүдэд шинэ “эцэг” /эх/- дээ дасах хугацаа олгон тэвчээртэй хандахад сургах Гэр бүлийн доторх харилцаа нээлттэй, илэн далангүй байлгах тал дээр эхнэр, нөхөр 2 анхаарах 	<ul style="list-style-type: none"> Шинэ гэр бүл доторх бүхий л харилцааг гэр бүлийн тухай болон бусад хуулийн дагуу зохицуулан хуулийн зөвлөгөө өгөгдөнө 	<ul style="list-style-type: none"> Эхнэр, нөхөр хоорондоо итгэлцлийн харилцааг үүсгэх Хүүхдүүд хойд эцэг /эх/-тэйгээ болон тэдний хүүхдүүдтэй эерэг харилцаатай байх Аливаа асуудлыг шийдвэрлэхдээ “манай-танай” гэхээс илүүтэйгээр бидний гэсэн хамтач уур амьсгалаар хандах

IV. ДҮРЭМ ГАРГАХ ҮЕ

Гэр бүлийн дүрэм боловсруулах үе шат

Товч агуулга

Энэ аргыг гэр бүлийн гишүүд хамтран өөрийн гэр бүлийн дүрэм гаргаж үүнийгээ хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэнэ.

Заавар:

1. Эхнэр нөхөр болон 12-с дээш насны хүүхэдүүд 7 хоногт **“Бидний гэр бүлийн аз жаргалын дүрэм”** бичиж ирэх даалгавар өгөх
2. Аав-ээж-Зөвлөгч 3 уулзаж эхнэр нөхрийн харилцааны дүрэм гаргана
3. Аав-ээж-хүүхэд-зөвлөгч нар уулзаж гэр бүлийн нийтлэг дүрэм гаргана.

Хүснэгт 2

Нөхөр, эхнэрийн дүрмийн загвар	Нөхөр, эхнэрийг дагаж ирсэн хүүхдийн дүрмийн загвар
Эхнэр, нөхрийг дагаж ирсэн хүүхдийн дүрмийн загвар	Гэр бүлийн гишүүд бүгд дагаж мөрдөх дүрмийн загвар

Ү. “АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” БҮЛГИЙН ТРЕНИНГ ХИЙХ ҮЕ

Товч агуулга

Тус бүлгийн тренинг нь дахин гэр бүл болсон гэр бүлүүдийг хамруулна /3-5 гэр бүлийн эхнэр нөхрүүд /хүүхэд оролцохгүй/. Тухайн гэр бүлүүдэд тулгамдаж буй нийтлэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх, цаашид урьдчидан сэргийлэх болон нэг нэгнээсээ сайн туршлагаа солилцох зэрэг зорилго агуулсан болно.

Нийт үргэлжлэх хугацаа: 2 цаг

Заавар: Доорх төлөвлөгөөний дагуу дасгалуудыг нийгмийн ажилтан /сэтгэл зүйч/ удирдан явуулна.

- **Мэндчилгээ**

Гэр бүлүүд хооронд мэндчилж тус тренингээс хүсэн хүлээ байгаа сэтгэгдлээсээ хуваалцана.

- **“Миний гэр бүл – миний баялаг” тархины давшилт**

Гэр бүлүүд 5 минутын дотор дахин гэр бүл болсон гэр бүлүүдийн өмнө тулгамддаг нийтлэг асуудлуудыг тоочино. Үр дүнд нь бүлэглэсэн 3-5 асуудлыг томъёолон гаргаж ирнэ.

Үүний дараагаар холимог багт /эхнэр нөхрүүд холилдоод/ хуваагаад тус асуудлуудыг шийдвэрлэх арга замуудыг санал болгох даалгавар өгнө.

Төгсгөлд нь багууд асуудлууд болон тэдний шийдлүүдээ ярилцаад тус ажлыг дуусгана.

- **Гэр бүлийн гишүүд захиа бичих**

Товч агуулга

Энэ аргыг гэр бүлийн бүх гишүүд тус тусдаа бие даан хийх бөгөөд нэг нэгэндээ сэтгэлийн үгээ хэлэх, эсвэл гомдолоо илэрхийлэх, талархсанаа ойлгуулахад оршино.

Заавар:

1. Гэр бүлийн гишүүн бүр бичих
2. Аав ээж ах эгч гэх бүх хүнд тус бүр бичнэ
3. Өөрийн гарааг бичих



- **Хамтын хүч бидний амьдралд**

Товч агуулга

Энэ аргыг хамтран дэмжих, нэг толгойноос хоёр толгой илүү гэсэн зарчмын ашиг тусыг ойлгуулах зорилгоор хэрэглэнэ.

Заавар:

1. Цаг үеийн эсвэл тухайн сэдэвтэй холбоотой асуултуудын жагсаалтыг гаргана.
2. Бие даан хариулахыг даалгана.
3. Тусдаа хариулж дуусахаар хос хосоороо нэгдэхийг хүснэ. Хосын гишүүн бүр өөрийн хариултыг нөгөө нөхөртөө танилцуулна.
4. Асуулт бүрд хоёулаа нийлээд өөрсдийнхөө ганцаараа хариулснаа сайжруулж, шинэ хариулт өгөхийг даалгана.
5. Бүх хос хариултаа бичсэний дараа хос бүрийн хариултыг бусад хосуудын хариуттай жишиж үзэх боломж олгоорой.

- **Дүгнэлт хэсэг**

Бүлгийн тренингэд оролцсон гишүүн болгон өөрийн ойлгож авсан зүйл болон мэдрэмжээ хуваалцан тус үйл ажиллагааг дүгнэн сэтгэгдэлээ хэлнэ.

ДҮГНЭЛТ

Дахин гэрлэсэн гэр бүлүүдийн талаас дээш хувь нь салдаг *ТҮВШИН* гадны улс орнуудад хийгдсэн судалгааны дундажтай харьцуулахад бага байгаа хэдий ч дахин гэрлэсэн гэр бүлийн асуудал шийдвэрлэх чадвар боломж нь харьцангуй бага байна. Тодруулбал дахин гэрэлсэн нөхөр эхнэр

дахин салах вий гэсэн айдаст автах, дахин алдаа гаргахаасаа айх, бие биедээ итгэх итгэл буурах, өөрийн болон эхнэр/нөхөр/-ийг дагаж ирсэн хүүхдүүдийг өөрийн хүүхэд мэт хайрлах хүмүүжүүлэх зэрэг олон асуудлууд тулгарч байна.

Иймээс дахин гэрлэсэн гэр бүлийг тогтвортой байлгах, хүүхдүүдэд эцэг эхийн хэд хэдэн салалт дамжих, хэд хэдэн хойд аав, ээжийн нүүр үзэх зэрэг олон асуудлуудтай тулгарахад хүргэхгүйн тулд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч гэр бүл судлаач нар хамтран ажиллаж гадаадын амжилттай загварыг хэрэгжүүлэн ажиллах нь дахин гэрлэсэн гэр бүлийн хүрээнд чухал асуудал болоод байна.

Мөн энэхүү загварыг сургагч багшаар дамжуулан нийгмийн ажилтан нарыг мэргэшүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.

НОМ ЗҮЙ

[1]. Белова В.А. Повторные браки и рождаемость: в кн.: Социально-демографические исследования брака, семьи, рождаемости и репродуктивных установок. Ереван, 1993. С. 13-15

[2]. Б. Оюун-Эрдэнэ “Монгол гэр бүлийн бүтэц, хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал” //Шинжлэх ухааны академийн мэдээ. 2012 он №03, хх. 37-49

[3]. Cartwright C., Gibson K. The effects of co-parenting relationships with ex-spouses on couples in step-families // Australian Institute of Family Studies. 2012

[4]. Hetherington E.M. Coping with Divorce, Single-Parenting, and Remarriage: A Risk and Resiliency Perspective. Mahwah, NJ: Lawrence Erlbaum. 1999